



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/240

Чингис хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Жижиг дунд, үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 2020 оны 6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Чингис хот дахь бизнес инкубатор төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, үнэлж дүгнэх, зохион байгуулалтаар хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Чогсомжав	Аймгийн Засаг даргыг орлогч
Нарийн бичиг:	Н.Ган-Адъяа	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Э.Мөнх-Эрдэнэ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Г.Лхагвахатан	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Г.Батгэрэл	"Хэнтий-Ус" ХХК-ний захирал
	Ч.Ариунаа-	"БЗӨБЦТС" ТӨХК-ний Хэнтий салбарын дарга
	Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
	Г.Нямхатан	Хэнтий Политехникийн коллежийн захирал

2. Бизнес инкубатор төвийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гарааны бизнес, үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Чогсомжав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011523